



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 419

Улаанбаатар хот

Г Стратеги, төлөвлөгөө батлах тухай Г

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.6 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. “Зайлсхийж болох сохрол, хараа сулралаас сэргийлэх, хянах стратеги”-ийг нэгдүгээр, “Стратеги хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я. Буянжаргал), хэрэгжилтэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв болон олон улсын төсөл хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгах замаар санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн хэлтэс (Д.Төмөрбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А. Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.

САЙД

Н.УДВАЛ



D:\barimt\tushaal

082462

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
10 сарын 03 өдрийн 419 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

ЗАЙЛСХИЙЖ БОЛОХ СОХРОЛ, ХАРАА СУЛРАЛААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ СТРАТЕГИ

УРИА. Харах эрхийг хүн бүрт

Нэг. Үндэслэл

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоолсноор 2014 онд дэлхий дээр 285 сая хүн харааны бэрхшээлтэй байгаагаас 39 сая хүн сохор, 246 сая хүн хараа сулралтай байна. Сохорлын 80 хувь нь зайлсхийж болох буюу урьдчилан сэргийлж, эмчлэгдэх боломжтой гэж дүгнэжээ. Дэлхий дээрх харааны бэрхшээлтэй хүмүүсийн 90 орчим хувь нь буурай хөгжилтэй болон хөгжиж байгаа орнуудад амьдардаг байна. Сохрол, хараа сулрал нь улс орны нийгэм, эдийн засаг төдийгүй өвчтөн, тэдний гэр бүлийн амьдралын чанарт нөлөөлж байдаг.

Монгол улсын Засгийн газар ДЭМБ-ын Чуулганаас гаргасан 56.26 тогтоолын дагуу “ВИЖН 2020, Хүний харах- Эрх, Зайлсхийж болох сохролыг устгая” уриаг дэмжиж 2003 оны 10 дугаар сард ЭМЯ, ДЭМБ-тай хамтарсан Тунхаг бичигт гарын үсэг зурсан юм. 2013 оны 5 сард болсон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 66-р чуулганы WHA66.4 тунхагаар “Олон улсын нүдний эрүүл мэнд, олон улсын үйл ажиллагааны төлөвлөгөө 2014-2019” баталсан. Энэхүү төлөвлөгөөний зорилго нь нүдний эрүүл мэндийн ирээдүйн зорилт, үйл ажиллагааг олон улсын түвшинд нэгдмэл зохион байгуулалттай болгох, үндсэн агуулга нь зайлсхийж болох сохролын улмаас харааны бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, зайлсхийж болохгүй сохролын үед өндөр мэргэшсэн эмчийн тусламж үзүүлэх, дэлхий нийтэд анхан шатны нүдний эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгоход оршиж байгаа юм.

Манай улсын төр засгаас нүдний тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахаар олон талт бодлогыг хэрэгжүүлж байна. Үүнд: Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 191 тоот тушаалаар батлагдсан “Сохролоос сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөр”, Эрүүл мэндийн сайдын 2006 оны 229 тоот тушаалаар батлагдсан Зайлсхийж болох сохрол, хараа сулралаас сэргийлэх, хянах стратеги, нүдний зонхилон тохиолдох өвчний оношилгоо эмчилгээний стандартууд батлагдан гарсан байдаг. Манай оронд зайлсхийж болох сохрол, хараа сулралын анхны стратеги 2006-2011 онд хэрэгжсэн бөгөөд ЭМЯ-аас 2012 онд үнэлгээ - хяналт хийж дүгнэсэн билээ.

Нүдний тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн бүх шатны байгууллагууд үзүүлж байгаа хэдийч улсын хэмжээнд хот, хөдөөгийн ард иргэдэд үзүүлэх нүдний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж нь харилцан адилгүй байна. Улсын хэмжээнд нийт 150 нүдний эмч ажиллаж байгаагийн 60 хувь нь улсын эмнэлэгт, 40 хувь нь хувийн

салбарт ажиллаж байна. Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа иргэдэд нүдний шилний үйлчилгээ үзүүлдэг газрууд бүгд хувийн хэвшилд хамаарагддаг ба иргэдэд сул харааны үйлчилгээ байхгүй байна.

Олон улсын өвчний ICD ангиллын 18 өвчнөөр бүлэглэн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоодгоос нүдний өвчнөөр нийт 9310 хүн байгаа нь хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгож байгаа хүмүүсийн 9%-ыг эзэлж, тэргүүлэх таван өвчний тоонд орж байна.


ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 2013 онд ЭМЯ, АШУҮИС хамтран “Зайлсхийж болох сохролын түргэвчилсэн судалгааг” 50-иас дээш насны 4040 хүнд хийхэд хоёр нүдний сохрол 2.2% (95% ИИ, 1.7-2.7%), хүнд хэлбэрийн сул хараа 2.1% (95% ИИ, 1.5-2.6%), байлаа. Хүн амын дунд сохрол, хараа сулралд хүргэдэг гол шалтгаан нь катаракт (38.9%), глауком (20%), эвэрлэгийн өвчин (13.3%) байснаас гадна рефракцийн гажиг, чихрийн шижингийн ретинопати, насжилтын шалтгаант шар толбоны дегенерацн зэрэг өвчнүүд ихэсч байгаа нь уг судалгааны дүнгээс нотлогдож байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын уриалсан зорилтуудыг хэрэгжүүлэх, зайлсхийж болох сохрол, хараа сулралыг бууруулах үе шаттай арга хэмжээнүүд авах, нүдний тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад дараагийн зайлсхийж болох сохрол, хараа сулралаас сэргийлэх, хянах стратеги, түүний хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах нэн шаардлагатай байна. Энэ стратеги, төлөвлөгөө нь 2020 он хүртэл нүдний эрүүл мэндийн тусламж үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагууд, эрүүл мэндийн эмч мэргэжилтнүүдийн удирдамж болохоос гадна цаашид хийж, хэрэгжүүлэх ажлын чиг хандлага болох юм.

Хоёр. Тулгамдаж байгаа асуудлууд

- Нүдний тусламж, үйлчилгээнд мөрдөгддөг стандарт, заавар, журам зэрэг эрхзүйн баримт бичиг дутмаг, шинэчлэх, шинээр боловсруулах шаардлагатай,
- Нүдний салбарын хүний нөөцийн болон давтан сургалтын төлөвлөлт, төсөв хангалтгүй,
- Нүдний тусламж, үйлчилгээний технологи, тоног төхөөрөмж хуучирсан, тоо хүртээмж хангалтгүй,
- Сохрол, хараа сулралын судалгаа, эрдэм шинжилгээний ажил цөөн,
- Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай хүн амын бүлэгт чиглэсэн нүдний тусламж, үйлчилгээний хүртээмж хангалтгүй,
- Нүдний мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн мэргэжилтнүүд дутагдалтай,
- Нүдний тусламж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн сан байхгүйгээс хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломж дутмаг,
- Хөдөө орон нутагт нүдний шилний үйлчилгээ сул, мэргэшсэн оптометрист дутмаг,
- Хүн амд чиглэсэн зайлсхийж болох сохрол, хараа сулралаас урьдчилан сэргийлэх мэдээлэл, нүдний эмгэгийн үед үзүүлэх анхан шатны тусламж,

- үйлчилгээний сургалт, сурталчилгааны ажил дутмаг,
- Харааны бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд тулгуурласан сэргээн засах тусламж, үйлчилгээ хангалтгүй,



Гурав. Алсын хараа, зорилго, зорилт

Алсын хараа

Нүдний эрүүл мэндийг дэмжих, зайлсхийж болох сохрол, хараа сулралаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлж оновчтой эмчлэн, сэргээн засах замаар хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх

Зорилго

Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын хэрэгцээнд тулгуурлан чанар, хүртээмж, хүний нөөцийг нэмэгдүүлж, чадавхийг нь дээшлүүлж хөгжүүлнэ.

Зорилтууд:

1. Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай эрхзүйн орчинг боловсронгуй болгох;
2. Хүн амд чиглэсэн нүдний эмгэгийн урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах,
3. Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээнд тохирсон хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах, хангах;
4. Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх;
5. Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ техник, технологийг нэвтрүүлэх;
6. Харааны бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд тулгуурласан сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх.

Дөрөв. стратегийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмууд

Энэхүү стратеги нь дараах үндсэн зарчимд тулгуурлана:

1. Тэгш, хүртээмжтэй, нотолгоонд тулгуурласан байх
2. Эрэлт хэрэгцээнд нийцсэн байх
3. Стратегийн хэрэгжилтэнд байгаа нөөц бололцоог дайчлах
4. Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
5. Олон улс, үндэсний болон салбарын бодлого, хөтөлбөр, стратегитэй уялдсан байна
6. Гэр бүл, олон нийт, салбар хоорондын тэгш оролцоог хангах

Тав. Стратегийн зорилгыг хангахад хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн
Алсын хараа, зорилгыг хангахад дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зорилт 1.

Нүдний тусламж, үйлчилгээнд шаардлагатай эрх зүйн орчинг боловсронгуй болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Нүдний тусламж, үйлчилгээнд мөрдөх стандарт, удирдамж, заавар боловсруулах

Хүрэх үр дүн:

Нүдний тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, эрхзүйн таатай орчин бүрдэнэ;

Зорилт 2.

Хүн амд чиглэсэн нүдний эмгэгийн урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах,

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлтийн чанар хүртээмж сайжруулах
 1. Хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх
 2. Хараа хамгаалах Дэлхийн өдөр, Глаукомын Дэлхийн өдрүүдийг жил бүр тэмдэглэж, хүн амд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих
 3. Төрийн болон төрийн бус байгууллагууд, эмч, мэргэжилтнүүд, олон нийтийг хамруулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг хийх
- Тусламж, үйлчилгээний чанар хүртээмж сайжруулах
 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд нэгдсэн мэдээллийн системд оруулж тодорхой болгох,
 2. Гадаад орноос авах тусламж, дэмжлэгийг нэмэгдүүлэх,
 3. Хагалгаа хийдэггүй аймгуудад явуулын багуудаар үйлчлэх,
 4. Нүдний тусламж, үйлчилгээний өртөг зардлын судалгаа хийж , санхүүжилтийг боловсронгуй болгох,

Хүрэх үр дүн:

Хүн амд чиглэсэн нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа сайжрах, нүдний тусламж, үйлчилгээг цогц бүрдлээр чанартай, хүртээмжтэй үзүүлнэ;

Зорилт 3.

Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээнд тохирсон хүний нөөцийг хөгжүүлэх бэлтгэх, чадавхижуулах, хангах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Нүдний тусламж, үйлчилгээний салбарын хүний нөөцийн төлөвлөлтийг хийх,
2. Нүдний эмгэгийн анхан шатны тусламжийн сургалтыг явуулж, сургагч багш нарыг бэлдэх,
3. Нүдний тусламж, үйлчилгээний чиглэлээр эмч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох,
4. Улсын аймаг, дүүргийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг эмнэлгүүдийг стадартын дагуу нүдний мэргэжлийн эмчээр бүрэн хангах,

Хүрэх үр дүн:

Нүдний тусламж, үйлчилгээг үзүүлэх хүний нөөцийн чадвар, хүртээмж нэмэгдэнэ.

Зорилт 4.

Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Мэргэжлийн нийгэмлэг, байгууллагуудын судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох,
2. Эрдэм шинжилгээ судалгаа явуулахад дэмжлэг үзүүлэх.

Хүрэх үр дүн:

Шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд суурилсан нүд судлалын шинжлэх ухаан хөгжинө.

Зорилт 5.

Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ техник, технологийг нэвтрүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг үе шаттайгаар явуулах,
2. Эмчилгээний шинэ арга, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх,

Хүрэх үр дүн:

Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг олон улсын түвшинд үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

Зорилт 6.

Харааны бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх.

- Нарийн бичгийн дарга- ЭМЯ-ны хариуцсан мэргэжилтэн
- Нарийн бичгийн дарга – Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
- Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн тэргүүн
- ЭХЭМҮТ-ийн Нүдний клиникийн эрхлэгч
- Монголын хараа зүйчдийн нийгэмлэгийн тэргүүн
- ДЭМБ-ын төлөөлөл (зөвшилцсөнөөр)
- Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч

8.3 Сохрол, хараа сулралаас сэргийлэх, хянах үйл ажиллагааг зохицуулах зөвлөл нь улирал дутам хуралдаж хэрэгжилтийн үйл ажиллагаан хяналт тавина.

Ес. Хамтын ажиллагаа ба түншлэл

Стратегийг хэрэгжүүлэхэд БСШУЯ, ХАХНХЯ, АШУҮИС, Улаанбаатар хот болон орон нутгийн засаг захиргаа, аймгуудын ЭМГ, нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагууд, ДЭМБ, ORBIS, АНУ-ын Deseret International Charities, Surgical Eye Expedition (SEE), Лондонгийн Их сургуулийн International Center for Eye Health (ICEH), Японы Жунтендо Их сургууль, Солонгосын Халлим Их сургууль, Тайландын Махидол Их сургууль, Азийн эмч нарын холбоо (AMDA), Австралийн BVVI олон улсын байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагуудтай боломжтой түншлэлүүдийн харилцааг дэмжиж хамтран ажиллана.

АРАВ. Стратегийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлтүүд

10.1 Үндэсний болон орон нутгийн хэмжээнд:

- Стратегийн хэрэгжилтэнд дунд хугацааны (2016 он) болон төгсгөлийн (2019 он) үнэлгээг хийнэ.
- Стратегийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээ, үнэлгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан, холбогдох байгууллагын оролцоотойгоор явуулна


10.2 Шалгуур үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	2014 он Суурь үзүүлэлт хэд байгаа тоо	2016 он Хэд болсон байх тоо бичих
1	Нүдний тусламж, үйлчилгээнд мөрдөгдөж байгаа стандарт, удирдамжийн тоо	1	8
2	Сохрол, хараа сулралын нотолгоонд тулгуурласан, тархвар зүйн судалгаа	0	1
3	Катарактын хагалгааны түвшин/1 сая хүн амд\	1000	1250
4	Нүдний Хагалгаа хийдэг аймгийн тоо	6	8
5	Аймаг бүсийн оношилгоо эмчилгээний төвүүд, хотын ЭМТ дээр хийгдэх сургагч багш нарын сургалтын тоо	1	6
6	Анхан шатны тусламжийн сургалтын тоо,	8	16
7	Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан нүдний эмч нарын тоо	10	25
8	Байгуулсан сул харааны төвийн тоо	0	2

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Зайлсхийж болох сохрол ба хараа сулралаас сэргийлэх, хянах Үндэсний стратеги төлөвлөгөө 2006-2010
2. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2010
3. Сэргээн засах тусламж үйлчилгээг хөгжүүлэх стратеги
4. Дүлийрэл, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги
5. WHO action plan of avoidable blindness 2009-2013y
6. WHO, Media centre. Visual impairment and blindness. Fact sheet №282, October 2011.
7. Үндэсний хөтөлбөрүүд дэх сохролоос сэргийлэх бодлогууд. ДЭМБ.1999, хууд
8. GJ Johnson, DC Minassian. The epidemiology of eye disease. Page1
9. WHO, Programmes and projects. Prevention of Blindness and visual impairment. Causes of blindness and visual impairment.
10. WHO Guidelines for Primary eye care: Strategies for Prevention of Blindness in National programs. page 26 (WHO,1997)

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
 12 сарын 03 өдрийн 419 дугаар
 тушаалын 2 дугаар хавсралт



ЗАЙЛСХИЙЖ БОЛОХ СОХРОЛ, ХАРАА СУЛРАЛААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ
 СТРАТЕГИЙН 2014-2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа						Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Шалгуур үзүүлэлтүүд
		2014	2015	2016	2017	2018	2019			
Зорилт 1. Нүдний тусламж үйлчилгээнд мөрдөх стандарт, удирдамж боловсруулах										
1.1	Глауком өвчний оношилгоо эмчилгээний заавар боловсруулах		+					ЭМЯ-ны БХЗГ, ОЭТХ, ЭТХ, МСЗ	НСМСЗ, АШУУИС, Нүдний үзүүлэх мэндийн байгууллагууд	Стандарт батлагдсан байна.
1.2	Дутуу нярайн ретинопатийн оношилгоо, эмчилгээний заавар боловсруулах		+					ЭМЯ-ны БХЗГ, ОЭТХ, ЭТХ, МСЗ	НСМСЗ, АШУУИС, ЭХЭМҮТ, Нүдний тусламж үзүүлэх мэндийн байгууллагууд	Батлагдсан заавар
1.3	Хүүхдийн нүдний гаж хөгжлийн оношилгоо, эмчилгээний заавар боловсруулах			+				ЭМЯ-ны БХЗГ, ОЭТХ, ЭТХ, МСЗ	НСМСЗ, АШУУИС, ЭХЭМҮТ, Нүдний тусламж үзүүлэх мэндийн байгууллагууд	Батлагдсан заавар

1.4	Рефракцийн гажгийн оношилгоо, эмчилгээний заавар боловсруулах			+				ЭМЯ-ны БХЗГ, ОЭТХ, ЭТХ, МСЗ	НСМСЗ, АШУУИС, тусламж эрүүл байгууллагууд	ЭХЭМҮТ, Нүдний үзүүлэх мэндийн	Батлагдсан заавар
1.5	Нүдний эмгэгийн анхан шатны тусламжийн заавар боловсруулах		+					ЭМЯ-ны БХЗГ, ОЭТХ, ЭТХ, МСЗ	НСМСЗ, Нүдний үзүүлэх мэндийн байгууллагууд	АШУУИС, тусламж эрүүл	Батлагдсан заавар
1.6	Катаракт өвчний оношилгоо, эмчилгээний заавар боловсруулах			+				ЭМЯ, БХЗГ, ОЭТХ, ЭТХ, МСЗ	НСМСЗ, Нүдний үзүүлэх мэндийн байгууллагууд	АШУУИС, тусламж эрүүл	Батлагдсан заавар
1.7	Чихрийн шижингийн ретинопатийн оношилгоо, эмчилгээний заавар боловсруулах		+	+				ЭМЯ-ны БХЗГ, ОЭТХ, ЭТХ, МСЗ	НСМСЗ, Нүдний үзүүлэх мэндийн байгууллагууд	АШУУИС, тусламж эрүүл	Батлагдсан заавар
Зорилт 2. Хүн амд чиглэсэн нүдний эмгэгийн урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах											
2.1 Нүдний эмгэгийн урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлтийг чанар хүртээмж сайжруулах											
2.1.1	Хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах	+	+	+	+	+	+	ХАХНХЯ, СЗХҮТ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, Эрүүл мэндийн байгууллагууд,	ЭМЯ-ны БХЗГ, ЭТХ НСМСЗ, АШУУИС		Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулагдсан байна.

								Мэргэжлийн нийгэмлэг холбоодууд		
2.2.2	Хараа хамгаалах Дэлхийн өдөр, Глаукомын Дэлхийн өдрүүдийг жил бүр тэмдэглэж, хүн амд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах	+	+	+	+	+	+	ЭМЯ-ны БХЗГ,ЭТХ НСМСЗ, АШУУИС, НЭМҮТ	ХАХНХЯ, БШУЯ,СЗХҮТ, Эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоодууд, Хараагүй иргэдийн үндэсний холбоо, Олон улсын байгууллагууд	Тэмдэглэлт өдрүүдэд үйл ажиллагаа зохион байгуулсан байна.
2.1.3	Төрийн болон төрийн бус байгууллагуудад мэдээлэл, сургалт, сурталчилгааг хийх	+	+	+	+	+	+	ЭМЯ-ны БХЗГ,ЭТХ, НЭМХ,	НСМСЗ, АШУУИС, ХАХНХЯ,СЗХҮТ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, Эрүүл мэндийн байгууллагууд Мэргэжлийн нийгэмлэг, холбоодууд, Хэвлэл мэдээллийн байгууллагууд, Хараагүй иргэдийн үндэсний холбоо, Олон улсын байгууллагууд	Сургалт сурталчилга аний ажлыг зохион байгуулсан байна.
2.1.4	Нүдний эрүүл мэндийн боловсрол олгох	+	+	+	+	+		ЭМЯ-ны БХЗГ,ЭТХ, НЭМХ,	ХАХНХЯ,СЗХҮТ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн	Хэвлэгдсэн тараах материалын


	сургалтанд хэрэглэх гарын авлага, тараах материал боловсруулж, хэвлүүлэх ,							НСМСЗ, АШУУИС, НЭМҮТ	газрууд, мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, Хараагүй үндэсний Олон байгууллагууд, аж ахуй нэгж компаниуд	Эрүүл тоо	
2.1.5	Олон нийтийн дунд нүдний эрүүл мэндийн боловсрол олгох сайн дурын идэвхтэн сургагч багш бэлтгэх	+	+	+	+	+	+	ЭМЯ-ны БХЗГ, ЭТХ, НЭМХ, НСМСЗ, АШУУИС	ХАХНХЯ-ны СЗХҮТ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, Эрүүл мэндийн байгууллага, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод олон улсын байгууллагууд	Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	
2.2 Нүдний эмгэгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах											
2.2.1	Катарактын хагалгааны үр дүнг тооцох аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх		+	+	+	+		ЭМЯ-ны БТГ, НСМСЗ,	Нүдний тусламж үзүүлдэг мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод,	эрүүл	Батлагдсан аргачлал
2.2.2	Нүдний хийдэггүй аймгуудад явуулын багууд мэс засал хийх		+	+	+	+	+	Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд,	ЭМЯ-ны БХЗГ-ын ЭТХ, НСМСЗ, Нүдний тусламж үзүүлдэг байгууллагууд		Аймгуудад хийгдсэн хагалгааны тоо

								мэргэжлийн нийгэмлэг, олон улсын байгууллага		
2.2.3	Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг зардлын судалгаа хийх	+	+	+				ЭМЯ-ны БТГ	Аймаг, эрүүл газрууд, мэндийн байгууллагууд, НСМСЗ	дүүргийн мэндийн эрүүл Өртөг зардлын судалгаа
2.2.4	Эмзэг бүлгийн хүмүүст торлог шилэнцрийн хагалгааны төлбөр, сул харааны туслах хэрэгслүүдийг даатгал, халамжийн системд хамруулах		+	+	+		+	ХАХНХЯ, ЭМЯ-ны БТГ	НДЕГ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн байгууллагууд, НСМСЗ	Батлагдсан тушаал
2.2.5	Сумдууд болон хотын захын бүсэд катаракттай өвчтөнүүдийг илрүүлэх тандалт үзлэгийг хийх	+	+	+	+	+	+	НСМСЗ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн	ЭМЯ-ны БХЗГ-ын ЭТХ, олон улсын байгууллагууд	Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо

								нийгэмлэг, холбоод		
2.2.6	Эмзэг бүлгийн хүмүүст зориулсан катарактын хагалгааг үнэ төлбөргүй хийх		+	+	+	+		ЭМЯ-ны БХЗГ-ын ЭТХ, НСМСЗ, АШУУИС	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн* байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Олон улсын байгууллагууд,	Хагалгаа хийсэн иргэний тоо 1
2.2.7	Сургуулийн хүүхдийн рефракцийн гажгийг илрүүлэх үзлэгийг зохион байгуулах		+	+	+	+	+	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, Ерөнхий боловсролын сургуулиуд, нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод	ЭМЯ, БШУЯ, НСМСЗ, АШУУИС, Олон улсын байгууллагууд,	Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо
2.2.8	Дутуу нярайн ретинопатийн	+	+	+	+	+	+	ЭХЭМҮТ, НСМСЗ,	Мэргэжлийн нийгэмлэг, холбоод,	Ретинопатийн тандалт

	тандалт шинжилгээг ЭХЭМҮТ-д тулгуурлан хийж хянах								Олон байгууллага	улсын	шинжилгээнд хамрагдсан хүүхдийн тоо
2.2.9	Глаукомтой өвчтөнүүдийн эрт илрүүлэлтийн үзлэгийг зохион байгуулах	+	+	+	+	+	+	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд, мэргэжлийн нийгэмлэг, холбоод	ЭМЯ-ны БХЗГ-ын НСМСЗ, Олон байгууллагууд	ЭТХ, ЭМХТ, улсын	Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо
10	Чихрийн шижингийн ретинопатийн үр дүнтэй хяналтын тогтолцоог бий болгож, бүртгэгдсэн өвчтөнүүдийг хянах	+	+	+	+	+	+	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод	ЭМЯ-ны БХЗГ-ын ЭТХ, ОЭТХ, ЭМХТ, НСМСЗ Олон байгууллагууд	улсын	Хяналтанд хамрагдсан иргэдийн тоо
орилт 3. Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээнд тохирсон хүний нөөцийг хөгжүүлэх бэлтгэх, чадавхижуулах, хангах											
3.1	Нүдний эмч, мэргэжилтний хүний нөөцийн судалгаа, мэдээллийн сантай болох			+				ЭМЯ-ны ТЗУГ, ХНХХ, ЭМХТ	НСМСЗ, АШУУИС, Нүдний тусламж үзүүлэх мэндийн байгууллагууд	эрүүл	Судалгаа хийгдэж, мэдээллийн сантай болсон байна.
3.2	Нүдний эмч мэргэжилтний		+	+	+	+		ЭМЯ-ны БХЗГ, ЭТХ,	НСМСЗ, Нүдний	АШУУИС, тусламж	Батлагдсан ажлын байрны

	ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж батлах /нүдний эмч, нүдний сувилагч, ортоптист, оптометрист, оптишн/							ОЭТХ	үзүүлэх мэндийн байгууллагууд	эрүүл	тодорхойлолт
3.3	Багшлах боловсон хүчинг бэлтгэх, чадваржуулах дотоод, гадаадын сургалтанд хамруулах	+	+	+	+	+	+	АШУУИС, ЭМХТ	НСМСЗ, тусламж эрүүл байгууллагууд	Нүдний үзүүлэх мэндийн	Сургалтад хамрагдсан багш нарын тоо
3.4	Нүдний тусламж, үйлчилгээний чиглэлээр эмч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр, стандартыг олон улсын түвшинд хүргэж шинэчлэн боловсруулах				+			АШУУИС, ЭМХТ	НСМСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Нүдний тусламж үзүүлэх мэндийн байгууллагууд, олон улсын байгууллагууд		Шинэчлэн батлагдсан сургалтын хөтөлбөр
3.5	Сургалтын материал, сургалтын орчин, нөхцлийг сайжруулах	+	+	+	+	+	+	ЭМЯ, БШУЯ, АШУУИС, ЭМХТ	НСМСЗ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Нүдний тусламж үзүүлэх мэндийн байгууллагууд, олон улсын байгууллага, төр, хувийн		Шинчлэгдсэн сургалтын материалын тоо




									хэвшлийн байгууллагууд	
3.6	Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай сургалтын чиглэлийг нэмэгдүүлэх		+	+	+	+	+	АШУҮИС, ЭМХТ	НСМСЗ, Нүдний тусламж эрүүл байгууллагууд	Нүдний үзүүлэх мэндийн сургалтын чиглэлийн хөтөлбөр
3.7	Нүдний эмгэгийн анхан шатны тусламжийн сургалтыг явуулж, сургагч багш нарыг бэлдэх	+	+	+	+	+	+	ЭМЯ-ны ЭТХ, НСМСЗ, НЭМҮТ, АШУУ ИС	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, Мэргэжлийн нийгэмлэг холбоод, Олон улсын байгууллагууд	Сургагч багшийн тоо
3.8	Гадаад орны туршлагатай мэргэжилтэнг урьж сургалт зохион байгуулах	+	+	+	+	+	+	ЭМЯ-ны ЭТХ, ЭМХТ, НСМСЗ, АШУҮИС	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, Эрүүл мэндийн байгууллагууд Мэргэжлийн нийгэмлэг холбоод, Олон улсын байгууллагууд	Сургалтын тоо
3.9	Хөгжингүй оронд эмч, мэргэжилтэн багшлах боловсон хүчинг сургах, туршлага судлах, давтан сургалтанд хамруулах	+	+	+	+	+	+	ЭМЯ-ны ХНУХХ, ЭМХТ, НСМСЗ, АШУҮИС	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, Эрүүл мэндийн байгууллагууд Мэргэжлийн нийгэмлэг холбоод, Олон улсын байгууллагууд	Сургалтанд хамрагдсан эмч, мэргэжилтэн багш нарын тоо

Зорилт 4 Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх

4.1	Мэргэжлийн нийгэмлэг, байгууллагуудын судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, жагсаалтыг гаргаж, судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлж, үр дүнг практикт нэвтрүүлэх	+		+		+		ЭМЯ-ны БХЗГ-ын ЭТХ, БТГ, ЭМХТ, НСМСЗ, АШУҮИС	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Олон улсын байгууллага	Батлагдсан судалгааны тэргүүлэх чиглэл
4.2	Эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр гадаад дотоодын хурал зохион байгуулах	+	+	+	+	+	+	ЭМЯ-ны БТГ, НСМСЗ, АШУҮИС	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Олон улсын байгууллагууд	Зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын тоо
4.3	Зайлсхийж болох сохролын түргэвчилсэн үнэлгээ (RAAB)-ээр сохрол, сул харааны тархалтыг тогтоох	+						НСМСЗ, АШУҮИС	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Олон улсын байгууллагууд	Судалгааны тайлан зөвлөмж

Зорилт 5 Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ техник, технологийг нэвтрүүлэх										
5.1	Эрүүл мэндийн байгууллагын шатлал бүрт нүдний тусламж үйлчилгээний шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн судалгаа хийж, жагсаалт гаргах, хангах	+	+	+	+	+	+	ЭМЯ-ны БХЗГ-ын ОЭТХ	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Олон улсын байгууллагууд	Судалгаа хийж шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт, хангагдсан тоног төхөөрөмжийн өртөг, тоо ширхэг
5.2	Тоног төхөөрөмжийг ашиглах аюулгүй ажиллагааны заавар боловсруулах, батлуулах	+	+	+				ЭМЯ-ны БХЗГ-ын ОЭТХ, ЭТХ, НСМСЗ	Нүдний тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд	Батлагдсан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны удирдамж
5.3	Батлагдсан жагсаалтын дагуу тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай явуулах		+	+	+	+	+	ЭМЯ-ны БХЗГ-ын ОЭТХ, НСМСЗ	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Олон улсын байгууллагууд	Хангасан тоног төхөөрөмжийн тоо
5.4	Сүүлийн үеийн өндөр нарийн технологи, дэвшилтэт аргыг	+	+		+	+		ЭМЯ-ны БХЗГ-ын ОЭТХ, НСМСЗ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн	Нэвтрүүлсэн

	нэвтрүүлэх								байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Олон улсын байгууллагууд	
5.5	Резидентүүдэд зориулсан вет лаб сургалтын түшиц эмнэлгүүдэд бий болгох	+	+					ЭМЯ, БШУЯ ЭМХТ, АШУУИС	Нүдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд	Байгуулагдсан веб лаб тоо
Зорилт 6 Харааны бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх										
6.1	Хамт олонд түшиглэн хараа хамгаалах, нүдний эмгэгээс урьдчилан сэргийлэх аргачлал боловсруулах		+	+	+	+		ЭМЯ, БШУЯ, ХАХНХЯ	НСМСЗ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, Хараагүй иргэдийн үндэсний холбоо, Олон улсын байгууллагууд, аж ахуй нэгж компаниуд	Батлуулсан аргачлал
6.2	Гэр бүл, байгууллага, хамт олонд сэргээн засах тусламж, үйлчилгээний чиглэлээр боловсрол олгох		+	+	+	+		ЭМЯ, БШУЯ, ХАХНХЯ	НСМСЗ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод,	Зохион байгуулагдсан үйл ажиллагааны тоо

	үйл ажиллагааг зохион байгуулах								Хараагүй иргэдийн үндэсний холбоо, Олон улсын байгууллагууд, аж ахуй нэгж компаниуд	
6.3	Сул харааны төв байгуулах		+		+			ЭХЭМҮТ, Төв эмнэлгүүд, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд, Мэргэжлийн нийгэмлэг, холбоод,	ЭМЯ, НСМСЗ, Хараагүй иргэдийн үндэсний холбоо, Олон улсын байгууллагууд, аж ахуй нэгж компаниуд	Байгуулагдсан сул харааны төвийн тоо